



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**





ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, spanning the width of the page.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БНСУ	Бүгд найрамдах солонгос улс
НББ	Нягтлан бодох бүртгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц



Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....	9
2.8.1.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ...	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	12
3.1	Авлагын талаар.....	12
3.1.1	Илрүүлэлт.....	12
3.1.2	Эрсдэл.....	12
3.1.3	Өгсөн зөвлөмж.....	12
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу.....	13
3.2	Үндсэн хөрөнгийн талаар.....	13
3.2.1	Илрүүлэлт.....	13
3.2.2	Эрсдэл.....	13
3.2.3	Өгсөн зөвлөмж.....	13
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу.....	13
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	14
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ДАРГА Д.ОДБАЯР ТАНАА

2019.04.25 № 869
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын материаллаг алдаагүй, үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР





2 Аудитын тайлан

2.1. Оршил

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 04 дүгээр сарын 05-наас 2019 оны 04 дүгээр сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Баярмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Үндсэн хуулийн цэц 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газарт 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн ТГ/157 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.



2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан заавар, аргачлалын дагуу горим, сорилыг гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг хийлгэн, холбогдох нотлох зүйлсийг баталгаажуулан, баримтжуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Үндсэн хуулийн цэцийн талаарх ерөнхий мэдээллийг А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Үндсэн хуулийн цэцийн эрхэм зорилгыг “Үндсэн хуулийн аливаа зөрчлөөс сэргийлэх, гарсан зөрчлийг таслан зогсоож, маргааныг магадлан шийдвэрлэх замаар Үндсэн хуулийг нэг мөр сахин хэвшүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиар Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлжээ. Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх, ажиллагаанд мэргэшил, арга зүй, хууль зүйн үйлчилгээг шуурхай үзүүлэх, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, гадаад харилцааг өргөжүүлэх, Үндсэн хуулийн шүүх хоорондын хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, үндсэн хуулийн болон бусад салбар эрх зүйн чиглэлээр онол, практикийн судалгаа хийх, мэдээлэл, лавлагаа бэлтгэх, цэцийн маргаан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх стратеги зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үндсэн хуулийн цэцийн дарга дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Үндсэн хуулийн цэц тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар Үндсэн хуулийн цэцийн даргын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг 3 үзүүлэлтээр баталгаажуулсныг дараах гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- ✓ Өргөдөл, мэдээлэл, хүсэлт 265-ийг хүлээн авч барагдуулалт, шийдвэрлэлтийн байдал 83 хувь;



- ✓ Бага суудлын хуралдаан 27 удаа хийж, 31 гомдол гаргасан асуудлын өргөдлийн барагдуулалт, шийдвэрлэлтийн байдал 87 хувь;
- ✓ Дунд, их суудлын 20 хуралдаанаар маргаан хянан шийдвэрлэж, ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх 25 өргөдөл, мэдээлэл гомдлын шийдвэрлэлт 80 хувийн гүйцэтгэлтэй буюу 2018 онд 265 өргөдөл, мэдээлэл хүлээн авснаас 220-ийг шийдвэрлэж, бага, дунд их суудлын нийт 47 удаагийн цэцийн хуралдаан хийж, Үндсэн хуулийн цэцийн 33 магадлал, 15 дүгнэлт, 3 тогтоол гаргасан байна.

Үндсэн хуулийн цэцийн удирдлага төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай,
- Хувь хүний орлогын албан татварын тухай,
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Үндсэн хууль,
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай,
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай зэрэг хуулиуд байна.

Тайлант хугацаанд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Үндсэн хуулийн цэцийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа боловч сайжруулах шаардлагатай байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.



Харин дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

Үндсэн хуулийн цэц нь байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих дотоод аудитын орон тоогүй бөгөөд өмнөх аудитын зөвлөмжийн дагуу дээрх чиг үүргийг гүйцэтгэх ажилтны орон тоо, цалингийн хэмжээг 2019 оны төсвийн төсөлд санал хүргүүлсэн боловч одоогоор шийдвэрлэгдээгүй байна.

Гэвч байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд тавих хяналт хангалттай гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Үндсэн хуулийн цэцийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

Төлөвлөх үе шатанд материаллаг байдлын түвшинг сонгосон суурь үзүүлэлтийн 2 хувиар тооцож, 40.7 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэх үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Материаллаг байдлыг түвшинг суурь үзүүлэлтээс 2 хувиар тооцсон нь тус байгууллагыг эрсдэл багатай гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа,



зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

2.8.1 Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 99.7 хувь буюу 1,551.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.3 хувь буюу 4.7 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно. Үүнд: Санхүүжилтийн орлогыг 1.2 сая төгрөгөөр илүү, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 1,550.7 сая төгрөгийн бүртгэлийн алдааг санхүүгийн тайланд залруулав.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Хүснэгт 1 Алдаа, зөрчил, түүний шийдвэрлэлт.

/сая төгрөг/

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Тоо	Дүн	Тоо	Дүн
								Тоо	Дүн				
1	Төсвийн шууд захирагч	2	4.7	-	-	-	-	2	4.7	-	-	-	-
	Дүн	2	4.7	-	-	-	-	2	4.7	-	-	-	-

Эх сурвалж: 2018 оны Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

2.8.1.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага “Койка”, Монгол Улсын Сангийн яамтай хамтарсан "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд цахим шүүхийн үйлчилгээний тогтолцоо бий болгох" төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн хүрээнд 2018 онд хандиваар 139 нэр төрлийн 1,682,842 ам.доллар буюу 4,135.6 сая төгрөгийн үнэ бүхий компьютер, тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна. Уг төсөл 2019 онд дуусах бөгөөд төслийн ажил дуусч, хөрөнгийг албан ёсоор тус байгууллагад хүлээлгэн өгч данс бүртгэлд тусгах тул дараагийн аудитаар үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ



хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Үндсэн хуулийн цэцийн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 3 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 2,032.9 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Тайлант хугацаанд урсгал үйл ажиллагааны санхүүжилт 1,693.0 сая төгрөг, хөрөнгийн санхүүжилт 339.3 сая төгрөг нийт 2,032.3 сая төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр авч, гүйцэтгэлээр 2,031.1 сая төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 1.2 сая төгрөгийн төсвийн хэмнэлтийг төвлөрүүлсэн байна. Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 99.9 хувьтай байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Үндсэн хуулийн цэцийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр ил тод мэдээлж ажилласан байна.

Үндсэн хуулийн цэцийн даргын болон Тамгын газрын шилэн дансны цахим хуудаст 2018 онд мэдээлэл байршуулсан байдлыг харуулбал:

- ✓ Үндсэн хуулийн цэцийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудаст нийт 212 мэдээлэл;
- ✓ Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны шилэн дансны цахим хуудаст нийт 146 мэдээлэл тус тус байршуулан ажилласан байна.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хавсаргав.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 75 хувьтай байна.

Өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу санхүүгийн үйл ажиллагаанд баримтлах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан ҮХЦ-ийн тамгын газрын даргын 2018 оны 70 захирамжаар баталгаажуулан, мөрдөж байна.

Мөн тус байгууллагад Төсвийн тухай хуулиар тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмжийн дагуу дээрх чиг үүргийг гүйцэтгэх ажилтны орон тоо, цалингийн хэмжээний төслийг 2019 оны төсвийн саналд тусгасан боловч одоогоор шийдвэрлэгдээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.



2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.



3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Үндсэн хуулийн цэцийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлагын талаар

3.1.1 Илрүүлэлт

2017 онд үүссэн байгууллагаас авах 0.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, гадаад томилолтын тийзний үнэнд 0.2 сая төгрөгийг илүү шилжүүлснийг авлагаар бүртгээгүй байна.

3.1.2 Эрсдэл

Авлага барагдахгүй байх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдсан байх, хууль, журам зөрчигдсэн байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэснийг хэрэгжүүлж ажиллах, авлагыг барагдуулах арга хэмжээ авах.



3.1.4 Байгууллагаас өгсөн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтан хүлээн зөвшөөрсөн.

3.2 Үндсэн хөрөнгийн талаар

3.2.1 Илрүүлэлт

Үндсэн хөрөнгийн шинж чанартай 3.8 сая төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг хяналтын камер, сүлжээ унагаагч зэрэг хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй байна.

3.2.2 Эрсдэл

Санхүүгийн тайлан дахь хөрөнгө буруу илэрхийлэгдэх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, хууль, журам зөрчигдсөн байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." гэснийг мөрдөж хөрөнгийг данс бүртгэлд бүртгэх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтан хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 09 дугаар 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

/ мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		30,216.4	29,861.0
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	20.8	20.8
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	704.2	798.9
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	29,491.4	29,041.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,626,544.1	3,509,366.7
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,626,544.1	3,509,366.7
Биет хөрөнгө		1,625,095.8	3,444,153.4
Биет бус хөрөнгө	13	1,448.3	65,213.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,656,760.5	3,539,227.8
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,656,280.2	3,539,227.8
Засгийн газрын хувь оролцоо		1,656,280.2	3,539,227.8
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		2,015,457.9	2,080,671.2
Хуримтлагдсан үр дүн		-365,733.6	-98,732.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		6,556.0	1,557,289.1
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,656,760.5	3,539,227.8



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

/ мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		1,595,069.9	2,032,354.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	35.5	15.0
Нийтлэг татварын бус орлого		35.5	15.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,595,034.4	2,032,339.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,680,607.0	1,765,353.2
УРСГАЛ ЗАРДАЛ		1,680,607.0	1,765,353.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,470,198.6	1,515,127.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		945,428.9	952,618.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		100,528.1	112,237.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		21,542.4	21,929.8
Хангамж, бараа материалын зардал		121,506.9	128,753.3
Эд хогшил, урсгал засварын зардал		31,849.7	73,515.7
Томилолт, зочны зардал		16,760.0	28,910.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		32,992.1	27,833.2
Бараа үйлчилгээний бусад зардал		199,590.6	169,328.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		210,408.4	250,226.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		-85,537.1	267,001.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-92,797.1	267,001.2



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

/ мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,595,069.9	2,032,354.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35.5	15.0
Нийтлэг татварын бус орлого	35.5	15.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,595,034.4	2,032,339.4
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,577,566.4	1,691,352.0
УРСГАЛ ЗАРДАЛ	1,577,566.4	1,691,352.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,367,158.0	1,441,110.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	942,692.6	951,264.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,696.3	114,151.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,542.4	21,929.8
Хангамж, бараа материалын зардал	107,213.1	124,441.8
Эд хогшил, урсгал засварын зардал	31,849.7	75,159.7
Томилолт, зочны зардал	16,760.0	28,910.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,992.1	31,505.2
Бараа үйлчилгээний бусад зардал	110,411.8	93,747.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	210,408.4	250,241.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	17,503.5	341,002.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	17,503.5	341,002.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,503.5	341,002.4
Дотоод эх үүсвэрээр	17,503.5	341,002.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-17,503.5	-341,002.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20.8	20.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20.8	20.8



4.4 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

/ мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,927,145.5	0.0	1,927,145.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-178,068.2	0.0	-178,068.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,749,077.3	0.0	1,749,077.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	-92,797.1	0.0	-92,797.1
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,656,280.2	0.0	1,656,280.2
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,656,280.2	0.0	1,656,280.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,656,280.2	0.0	1,656,280.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	1,550,733.1	0.0	1,550,733.1
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	65,213.3	0.0	65,213.3
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	267,001.2	0.0	267,001.2
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,539,227.8	0.0	3,539,227.8



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	20,758.00	(20,758.00)	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,692,967,000.00	1,691,720,186.00	1,246,814.00	99.9
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,692,967,000.00	1,691,720,186.00	1,246,814.00	99.9
Бараа, үйлчилгээний зардал	1,443,987,600.00	1,442,740,800.00	1,246,800.00	99.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	951,264,100.00	951,264,100.00	-	100.0
Үндсэн цалин	639,137,500.00	639,137,500.00	-	100.0
Нэмэгдэл	224,736,800.00	224,736,800.00	-	100.0
Унаа, болон бусад нөхөн олговор	45,019,300.00	45,019,300.00	-	100.0
Урамшуулал	42,370,500.00	42,370,500.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,151,600.00	114,151,600.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	76,101,100.00	83,464,989.89	(7,363,889.89)	109.7
Тэтгэмжийн даатгал	9,512,600.00	9,595,409.00	(82,809.00)	100.8
ҮОМШӨ ний даатгал	7,610,100.00	7,610,100.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	1,902,500.00	1,902,500.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	19,025,300.00	11,578,601.11	7,446,698.89	60.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,929,800.00	21,929,800.00	-	100.0
Гэрэл цахилгаан	6,954,000.00	9,814,899.51	(2,860,899.51)	141.1
Түлш, халаалт	10,467,300.00	7,983,122.19	2,484,177.81	76.3
Цэвэр, бохир ус	4,508,500.00	4,131,778.30	376,721.70	91.6
Хангамж, бараа материалын зардал	126,144,300.00	126,071,800.00	72,500.00	99.9
Бичиг хэрэг	8,680,100.00	8,680,100.00	-	100.0
Тээвэр (шатахуун)	72,400,000.00	72,400,000.00	-	100.0
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	14,908,900.00	12,147,929.75	2,760,970.25	81.5
Ном, хэвлэл	23,265,000.00	25,910,120.25	(2,645,120.25)	111.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	780,000.00	845,850.00	(65,850.00)	108.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	6,110,300.00	6,087,800.00	22,500.00	99.6
Эд хогшил худалдан авах	75,164,700.00	75,159,700.00	5,000.00	99.9
Багаж, техник, хэрэгсэл	3,820,000.00	3,049,580.00	770,420.00	79.8
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	343,000.00	1,136,400.00	(793,400.00)	331.3
Урсгал засвар	71,001,700.00	70,973,720.00	27,980.00	99.9
Томилолт, зочны зардал	28,910,900.00	28,910,900.00	-	100.0
Дотоод албан томилолт	28,910,900.00	28,910,900.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	31,756,200.00	31,505,200.00	251,000.00	99.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,640,000.00	11,640,000.00	-	100.0
Мэдээллийн технологийн зардал	17,476,200.00	17,225,200.00	251,000.00	98.6
Газрын төлбөр	2,640,000.00	2,640,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	94,666,000.00	93,747,700.00	918,300.00	99.0



Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа үйлчилгээний бусад зардал	1,485,000.00	1,485,000.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	93,181,000.00	92,262,700.00	918,300.00	99.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	248,979,400.00	248,979,386.00	14.00	100.0
Засгийн газар хоорондын шилжүүлэг	2,849,000.00	2,849,000.00	-	100.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	2,849,000.00	2,849,000.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	246,130,400.00	246,130,386.00	14.00	100.0
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	243,130,400.00	243,130,386.00	14.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	340,000,000.00	339,372,387.00	627,613.00	99.8
Дотоод эх үүсвэрээр	340,000,000.00	339,372,387.00	627,613.00	99.8
Тоног төхөөрөмж	340,000,000.00	339,372,387.00	627,613.00	99.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,032,967,000.00	2,031,107,573.00	1,859,427.00	99.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,032,967,000.00	2,031,092,573.00	1,874,427.00	99.9
Улсын төсвөөс санхүүжих	1,692,967,000.00	1,691,720,186.00	1,246,814.00	99.9
Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	340,000,000.00	339,372,387.00	627,613.00	99.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	15,000.00	(15,000.00)	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	15,000.00	(15,000.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	20,758.00	(20,758.00)	-
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт	-	15,000.00	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	49.00	49.00	-	100.0
Удирдах ажилтан	10.00	10.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	33.00	33.00	-	100.0
Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.0



5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудит	Аудитын код:	САГ-2019/4/СТА-ТЭЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Үндсэн хуулийн цэц			Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	3	4	5	8	9
1	2017 онд үүссэн байгууллагаас авах 0.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, Гадаад томилолтын тийзний үнэнд 0.2 сая төгрөгийг илүү шилжүүлснийг авлагаар бүртгээгүй байна.	0.9	Зөвлөмж өгсөн.	Ахлах нягтлан бодогч	Б.Эрдэнэбат
2	Үндсэн хөрөнгийн шинж чанартай 3.8 сая төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг хяналтын камер, сүлжээ унагаагч зэрэг хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй байна.	3.8	Зөвлөмж өгсөн.	Ахлах нягтлан бодогч	Б.Эрдэнэбат
		4.7			